

ГХЯ-НЫ ГАДААД СУРТАЛЧИЛГАА, СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ЗАХИРАЛ Д.БУЛГАНЫ ХЭЛСЭН ҮГ

Эрхэм хүндэт Элчин сайд Цай Вэньруй, Шинжлэх Ухааны Академийн тэргүүн дэд ерөнхийлөгч Г.Чулуунбаатар, Олон улс судлалын хүрээлэнгийн захирал Д.Золбоо болон эрхэм хүндэт эрдэмтэн судлаачид та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгаж байна. Миний бие Монгол Улсын Гадаад Харилцааны сайд Б.Батцэцэгийн чин сэтгэлийн мэндчилгээг дэвшүүлж, хурлын үйл ажиллагаанд өндөр амжилт хүссэнийг та бүхэнд уламжилж байна.

Монгол Улс-БНХАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт өргөжин хөгжиж, эдүгээ бүс нутгийн улс орнуудын үлгэр жишээ харилцаа болон хөгжиж байгаа билээ. «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр»-ийг хоёр тал харилцан баталж, 1952 оны 12 дугаар сарын 29-ний өдөр Улаанбаатар хотноо батламж жуух бичгээ солилцсоноос хойш эдүгээ 70 жилийн хугацаа өнгөрсөн байна. Энэхүү хэлэлцээр нь Монгол-Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны чухал бүрэлдэхүүн хэсэг болох эдийн засаг, соёл хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх эрх зүйн үндэс болсон бөгөөд эдүгээ талуудын хооронд худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Хятадын засгийн газар хоорондын комисс, Эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн Монгол-Хятадын хамтарсан зөвлөл, Монгол-Хятадын хүмүүнлэгийн солилцооны зөвлөл зэрэг хоёр орны худалдаа, эдийн засаг, соёлын харилцаа, хамтын ажиллагааг зохицуулах үүрэг бүхий механизм байгуулан хоёр тал ажиллаж байна.

Хэлэлцээрийн хоёрдугаар зүйлд энэхүү хэлэлцээрийг үндэслэн, мөн үүнийг бэхжүүлэх журмаар БНМАУ, БНХАУ-ын аж ахуй, худалдаа, соёл гэгээрлийн зохих албан газруудын хооронд жич тодорхой хэлэлцээрүүд тогтоогдож байх болно гэж заасан байдаг. Энэ жишгийн дагуу хоёр орны бүхий л салбар хоорондын хамтын ажиллагааны салбарт байгуулагдсан 140 орчим гэрээ хэлэлцээрүүд өнөөдөр хүчин төгөлдөр хэвээр байгаа нь хөрш зэргэлдээ манай хоёр орны харилцаа хэр өргөн хүрээнд хөгжиж байгаагийн тод жишээ гэж илтгэж байна.

Дэлхий дахины өмнө тулгарсан цар тахлын хүндрэл, бэрхшээлтэй цаг үед ч манай хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа тасралтгүй урагшилж, улс төрийн итгэлцэл, ард түмэн хоорондын харилцан ойлголцон гүнзгийрэн бэхжиж, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжин хөгжиж байгаад Монголын тал сэтгэл хангалуун байдаг билээ. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2022 оны 2 дугаар сард БНХАУ-д айлчилж, “Бээжин 2022” өвлийн

олимпын нээлтийн үйл ажиллагаанд оролцож, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн, Гадаад хэргийн сайд Ван И, БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Ли Жанышу нар энэ онд Монгол Улсад албан ёсны айлчлал хийж, худалдаа, эдийн засаг, соёл хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааны асуудлаар өргөн хүрээтэй тохиролцоонд хүрсэн билээ. Мөн хоёр орны төрийн тэргүүн нар саяхан болж өнгөрсөн ШХАБ-ын гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын зөвлөлийн хуралдааны үеэр уулзаж, Монгол-Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааны талаар өргөн хүрээний асуудлаар санал солилцсон билээ. Эдгээр дээд өндөр түвшний айлчлал, арга хэмжээ нь Монгол-Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг бэхжүүлэх, хөгжлийн уялдаа холбоог гүнзгийрүүлэх, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал түлхэц болсон.

Эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулагдсан 70 жилийн хугацаанд хоёр улсын боловсрол, соёл, шинжлэх ухаан, хүүхэд залуучууд, орон нутгийн солилцоо, эрүүл мэнд, спорт, хэвлэл мэдээлэл, аялал жуулчлал, хөдөлмөр нийгэм хамгаалал зэрэг салбарт найрсаг хамтын ажиллагаа шинэ шатанд өргөжин хөгжиж ирсэн билээ. Монголын соёл мэдээллийн төв тун удахгүй Бээжин хотноо нээгдэн үйл ажиллагаагаа эхлүүлэх гэж байгаа бөгөөд хоёр тал харилцан соёлын төв байгуулсан нь сайн хамтын ажиллагааны нэгэн тод жишээ юм. Энэхүү Бээжин хотноо байгуулагдсан соёл мэдээллийн төв нь Монгол Улс, БНХАУ-ын засгийн газар хоорондын соёлын төв харилцан байгуулах тухай хэлэлцээрийн хүрээнд байгуулж байгаагаараа онцлог бөгөөд цаашид энэхүү төвийн үйл ажиллагаа нь Монгол-Хятадын ард түмний харилцан ойлголцол, уламжлалт найрамдал харилцааг улам бэхжүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэн, гүнзгийрүүлэхэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

БНХАУ нь манай улсын худалдаа, хөрөнгө оруулалтын чухал түнш юм, Монгол-Хятадын худалдааны эргэлт сүүлийн жилүүдэд манай улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 60 гаруй хувийг бүрдүүлдэг бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээгээр тэргүүлдэг улс орнуудын нэг билээ. 2014 онд байгуулсан хоёр орны худалдаа, эдийн засгийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрт хоёр орны худалдааны хэмжээг 2020 онд 10 тэрбум долларт хүргэх зорилт дэвшүүлсний дагуу цар тахлын онцгой цаг үед 2021 онд худалдааны хэмжээ 10.1 тэрбум хүрсэн нь одоогийн байдлаар түүхэн дээд амжилтыг тогтоосон билээ. Түүнчлэн БНХАУ-аас үзүүлж буй буцалтгүй тусламж нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж ирснийг энд тэмдэглэхэд таатай байна.

Монгол-Хятадын эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааны хүрээг өргөтгөн хөгжүүлэх зорилгоор хоёр орны хөгжлийн шинэ үетэй уялдуулан эрх тэгш, харилцан ашигтай, хамтдаа хөгжих зарчмын дагуу Монгол Улс-БНХАУ-

ын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг хоёр дахь удаагаа шинэчлэн байгуулахаар талууд ажиллаж байна. БНХАУ нь өөрөө хөгжлийн үр өгөөжийг хөрш зэргэлдээ орнуудтай хуваалцан, хамтдаа хөгжих бодлогыг тууштай хэрэгжүүлж буйг сая Элчин сайд үгэндээ дурдлаа. Иймд хоёр улсын удирдагч нарын түвшинд ярьж тохиролцсон олон чухал ажлыг эрх тэгш, харилцан ашигтай хамтран хөгжих зарчмын дагуу тус тусын давуу тал, нөөц бололцоонд тулгуурлан хоёр талын стратегийн урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх нь зүйтэй. Монгол-Хятадын худалдаа, эдийн засаг, соёл хүмүүнлэгийн хамтын ажиллагааны агуулга түвшнийг бүх талаар ахиулахын төлөө бид хамтдаа хичээн ажиллах ёстой.

Монгол-Хятадын харилцааны ирээдүйг бид бүгд үргэлж өөдрөг сайхнаар төсөөлж, үүндээ ч итгэлтэй байдаг. Хамтын ажиллагааны шинэ боломжууд, шинэ ололт амжилт, шинэ түүхэн хуудсыг нээхэд эрдэмтэн судлаачид та бүхний оролцоо нэн чухал байдаг билээ. Өнөөдрийн хурлаар эрхэм эрдэмтэн судлаачид та бүхэн хоёр орны хамтын ажиллагааны шинэ боломжуудыг ярилцаж, олон сайхан үнэ цэнтэй санал санаачилгуудыг дэвшүүлж, Монгол Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд үргэлжлүүлэн чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Эрдэм шинжилгээний хурлын үйл ажиллагаанд өндөр амжилт хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.